



101 Page



102 Page

Moses2

-Moses2-

Тайлбарлагч Мосе, ордонд өсч хүмүүжин нас биеэнд хүрэв. Тэрээр боолын амьдралаар зовж байгаа ахан дүүсээ хараад сэтгэл нь өвдөж байлаа. Нэгэн өдөр, Мосе Египет хүний ажлын тайлбай дээр очжээ. Гэтэл тэнд Египет хүн Израиль хүнийг хэрцгийгээр зодож байгааг харчихав.

Египет хүн (ташуурын чимээ) хурдан босооч!! Ажил уул овоо шиг их байгааг харахгүй байна уу?

Еврей хүн Яа яа!!

Тайлбарлагч Мосе өөртэй нь адил Еврей хүн бусдад зодуулж байхыг хараад тэвчиж чадсангүй. Тэгээд тэр тэсэлгүй өнөөх Египет хүнийг алчихжээ. Мосе, Египет хүнийг алсан тухай яриа хааны ордонд сонсогдов. Фараон хаан үүнийг сонсоод Мосег алахаар хайжээ. Мосе Фараон хаанаас зугтан, Мидианы цөлд ирэв.

Тайлбарлагч Ингээд Мосе, цөлд хонь хариулан амьдрах болов. Тэрээр Египетэд ханхүү байснаа мөн Израильчуудын боолын амьдралыг бага багаар мартаж байлаа. Гэтэл нэгэн өдөр, Мосе хонио хариулан явсаар Хороб ууланд ирээд маш хачирхалтай зүйлийг харж гэнэ.

Мосе “Хөөх!! Бургас модонд гал дүрэлзэж байх чинь, гэхдээ яагаад мод нь шатахгүй байна вэ?

Тайлбарлагч Яг тэр үед Бурханы дуу хоолой түүнд сонсогдов.

Бурхан Мосе ! Мосе !!

Мосе Та хэн бэ?

Бурхан “Мосе! Би бол чиний өвөг дээдэс болох Абрахам, Исаак, Иаковын Бурхан байна.”

Тайлбарлагч Мосе ихэд айн сандарч өвдөг сөгдөн нүүрээ нуув. Бурхан үргэлжлүүлэн түүнтэй ярилаа.

Бурхан “Мосе, Би Өөрийн ард түмний Египетэд зовон шаналж байгаа дуу хоолойг сонслоо. Одоо би чамайг Фараон уруу явуулж Өөрийн ард түмнийг аврах болно.”

Тайлбарлагч Мосе Бурханы үгийг сонсоод ихэд эмээв.

Мосе “Бурхан минь, өчүүхэн би яаж ийм ажил хийж чадах билээ? Би бас сайн ярьж чадахгүй.”

Бурхан “Бүү санаа зов. Би чамтай заавал хамт байх болно. Чиний ах Аароноор дамжуулан хэлэх үгээ яриулах болно”



103 Page

- Тайлбарлагч** Тэгээд Мосе, Аарон хоёр Египетийн хааны ордонд очив.
- Мосе** “Бурханы ард түмнийг чөлөөлөн явуулж Эзэн Бурханд нь үйлчлүүлж өгнө үү”
- Фараон** “Юу юу гэнэ? Бурхан гэж хэн юм бэ? Надад ямар хамаатай юм бэ? Би Бурханыг мэдэхгүй учир Израильчуудыг явуулж чадахгүй. Огтхон үгүй.”

Тайлбарлагч Египетийн хаан, Израильчуудыг өөрийнхөө боол байлгахын тулд тэднийг явуулсангүй. Фараон хаан, Мосегийн үгэнд итгэхгүй байсанд тэр Аароны таягийг авч шиджээ. Таяг, тэр дороо могой болж хувирав. Тэгсэн ч Фараон хаан итгэхгүй байлаа. Харин ч бүр эсрэгээрээ Израильчуудад хүнд ажил даалгажээ.



104 Page

- Тайлбарлагч** Бурхан ихэд уурлав.
- Бурхан** “Мосе, Египетийн бүх голыг цус болго!”
- Тайлбарлагч** Бурханы хэлсний дагуу бүх гол цус болжээ. Египет хүмүүст уух ус олдохгүй болов. Тэгсэн ч Фараон зөрсөн хэвээр байлаа. Бурхан түүний зөрүүд занг дарахын тулд олон гамшигуудыг Египет нутагт буулгав. Мэлхий, ялаа, халдварт өвчин, яр шарх, мөндөр, царцаа, харанхуй, гэх мэт гамшигуудыг үзүүлжээ. Тэгсэн ч Фараон Израильчуудыг явуулахгүй байлаа. Тэгээд Бурхан арав дахь гамшигийг буулгахаар болжээ.
- Бурхан** “Мосе, Египетэд төрсөн хүн ба амьтны ууган болгоныг би үхүүлэх болно. Харин Израильчуудад хэл. Хурганы цусыг хаалганыхаа тогтонд түрхсэн айл болгоныг үхэл өнгөрөн явах болно”
- Тайлбарлагч** Харанхуй шөнө, Египетийн газар бүрээс уйлах дуу тасралтгүйгээр сонсогдов. Арав дахь гамшигаар Египетийн ууган болгон нь бүгд үхжээ.



105 Page

- Тайлбарлагч** Фараон хааны ууган хүү ч бас үхэв. Фараон хаан юу ч хийж чадахгүй байлаа. Тэгээд Мосег дуудуулан хэлэв.
- Фараон** “Чи Израиль ард түмнээ дагуулаад энэ газраас явж үз! Эндээс явж өөрийнхөө Бурханд үйлчил. Та нар өөрсдийн хонь мал сүргээ ч аваад яв.”
- Тайлбарлагч** Ингээд, Израильчууд Мосегоор удирдуулан Египет газрыг орхин явцгаажээ.